



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4196

Улаанбаатар хот

Г Эрчимт эмчилгээний бэлэн байдлыг хангах
талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 35 дугаар зүйлийн 35.2, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.17, 9.15, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоолын 10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвартай иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, коронавируст халдвартын тархалтын улаан түвшинд шилжсэнтэй холбогдуулан ард иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, халдвартын цар тахлыг хохирол багатай даван туулах зорилгоор аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгийн эрчимт эмчилгээний бэлэн байдлыг хангахад чиглэн дараах арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай:

- 2.1. Эмнэлгийн орны дээд хязгаарт багтаан нийт орны 10 хувийг стандартад нийцсэн эрчимт эмчилгээний ор болгон, ажиллах хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах; (уг эрчимт эмчилгээний оронд үндсэн тусламжийн ор орсон)
- 2.2. Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, мэдээгүйжүүлгийн мэргэшсэн эмч, сувилагчийг коронавируст халдвартай хүнд, нэн хүнд өвчтөний эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ажиллуулах;
- 2.3. Коронавируст халдвартай иргэнд үйлчлэх эрчимт эмчилгээний тасгийн зохион байгуулалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтний ажиллах, амрах орчин нь халдвартын сэргийлэлтийн дэглэм, журмын хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдүүлэх;
- 2.4. Эрчимт эмчилгээнд шаардлагатай хүний нөөцийн бэлэн байдлыг хангахад чиглэсэн төлөвлөлт, судалгаанд үндэслэн эмнэлгийн

мэргэжилтнийг сэлгүүлэн ажиллуулах, бусад эмнэлгээс дайчлах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах;

- 2.5. Хүнд болон нэн хүнд өвчтөнг эмнэлэг хооронд шилжүүлэх асуудлыг эмнэлзүйн зөвлөх, эмнэлгүүдийн эмчилгээ эрхэлсэн орлогч, эрчимт эмчилгээний эмч нар харилцан зөвшилцэж шуурхай шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд зөвлөн туслах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх багийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс томилох;
- 2.6. Коронавируст халдварт дэлгэсэн энгийн орны 50 хувьд хүчилтөрөгч эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх;
- 2.7. Ор дэлгэсэн эмнэлгийн үндсэн тусlamж, үйлчилгээг тасалдуулахгүй байх зохицуулалтыг хийх;
- 2.8. Коронавируст халдвартын оношилгоо, эмчилгээ, халдвартын сэргийлэлтийн холбогдох журам, зааврын дагуу эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангах;
- 2.9. Үйлчлэх хүрээний хуваарийн дагуу хариуцсан дүүргийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжин ажиллана.

3. Эрчимт эмчилгээний хүний нөөцийг бүрдүүлэхэд чиглэн дараах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны Хүний нөөц, сургалтын баг (Б.Бумдэлгэр), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), эрүүл мэндийн байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай:

- 3.1. Хүний нөөцийн бэлэн байдлын төлөвлөлт, судалгаанд үндэслэн дайчлан ажиллах эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн санг үүсгэх;
- 3.2. Дархлаажуулалт, тандалтын үйл ажиллагаанд дайчлагдаж байгаа эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, яаралтай тусlamжийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, резидент эмч нарыг эргүүлэн татах, эрхэүйн орчныг бүрдүүлэх;
- 3.3. Төр, хувийн хэвшил, мэргэжлийн нийгэмлэг холбоо, сургалт эрхлэх байгууллагатай хамтран эрчимт эмчилгээний сувилагчийн нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах;
- 3.4. Ор дэлгэсэн эрүүл мэндийн байгууллагад нэмэлтээр дайчлан ажиллах эмнэлгийн мэргэжилтний нарийвчилсан төлөвлөлтийг гаргаж, баталгаажуулах;
- 3.5. Дайчлагдан ажиллах эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмнэлзүй, халдвартын сэргийлэлт, сэтгэлзүйн сургалтыг зохион байгуулах, цахим хичээлийн санг бүрдүүлж судлах боломжийг бүрдүүлэх.

4. Үндэсний хэмжээнд эрчимт эмчилгээний оношилгоо, эмчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоход чиглэсэн дараах арга хэмжээг зохион байгуулахыг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны Хариу арга хэмжээний багийн ахлагч, Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Буяントогтох), Эмнэлзүйн зөвлөх баг, Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай:

- 4.1. Коронавируст халдварын хэвтүүлэн эмчлэх орны төлөвлөлтөд тодотгол хийж, нэмж дэлгэх орны нөөцийг гарган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
 - 4.2. Аймаг, дүүрэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн туслах чиг үүрэг бүхий эмнэлзүйн зөвлөх багийг шинэчлэн байгуулж, ажиллах хуваарийг гаргах;
 - 4.3. Эмнэлгийн туссламж, үйлчилгээний нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.
5. Коронавируст халдварын үеийн эрчимт эмчилгээний хүний нөөцийн хомсдох эрсдэлийг бууруулах зорилгоор эрчимт эмчилгээ, яаралтай туссламж, мэдээгүйжүүлгийн эмч нарыг дархлаажуулалтын давтан тунд яаралтай хамруулахыг дархлаажуулалтын ажлын хэсгийн ахлагч Төрийн нарийн бичгийн дарга (Ц.Эрдэмбилэг), Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан)-т тус тус үүрэг болгосугай.
6. Коронавируст халдварыг эмчлэхтэй холбоотой шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн тооцоо, судалгааг гаргаж, санхүү, хөрөнгө оруулалтын багт өгөх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны Нөөцийн хангалтын багийн ахлагч, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дэд дарга (Н.Гэрэлт-Од), Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар (Д.Нарантуяа)-т тус тус даалгасугай.
- 6.1. Эрчимт эмчилгээнд шаардлагатай унтуулах, тайвшруулах эм, антибиотик, шаардлагатай эмийн нөөц, хаалттай соруулгын систем, видео ларингоскопийн хангалтыг яаралтай бүрдүүлэх;
 - 6.2. Хүчилтөрөгч ханган нийлүүлэгч үйлдвэртэй нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмээг авах;
 - 6.3. Эрүүл мэндийн байгууллагын хүчилтөрөгчийн үйлдвэрийн тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих;
 - 6.4. Цэргийн төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлгийн ЭКМО аппаратын нийлүүлэлт, ашиглалтын бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах;
 - 6.5. Коронавируст халдварын хэвтүүлэн эмчлэх энгийн орны 50 хувийг хүчилтөрөгчийн эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэн хэсэгчилсэн систем, хүчилтөрөгчийн баллон, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;
 - 6.6. Цусны хийжилтийг үзэх оношилгооны аппаратын хангалтын нэмэгдүүлэх.
7. Коронавируст халдварын тархалтын нөхцөл байдалд үндэслэн эрчимт эмчилгээний орныг нэмэгдүүлэхтэй холбогдуулан шаардагдах санхүүжилт, хөрөнгө оруулалтын тооцоог, тоног төхөөрөмжийн хангалт хийж, худалдан авалтыг зохион байгуулж, урвалж оношлуур шийдвэрлэж, дайчлагдан ажиллахад шаардагдах цалин урамшууллыг шийдвэрлэх, гүйцэтгэлийн санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар

(Д.Нарантуяа), Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т зөвшөөрсүгэй.

8. Коронавируст халдвартын голомтын ариутгал, халдвартын сэргийлэлт, тандалтын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттер)-д даалгасугай.

9. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд (Б.Баттүвшин)-д даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 11. едрийн 196 дугаар тушаалын хавсралт

Коронавируст халдвартай иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ үзүүлэл эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хуваарь

Эмнэл зүй	Хүн ам	Сонгинохайрхан дүүрэг	Хан-Уул дүүрэг	Баянгол дүүрэг	Баянзүрх дүүрэг	Чингэлтэй дүүрэг	Сүхбаатар дүүрэг	Налайх дүүрэг	Багахангай дүүрэг	Баганчур дүүрэг	Орон нутаг
Эрсдэлтэй хөнгөн	Энэүт-II	Ачтан эмнэлэг	СЗКЭ	Ачтан эмнэлэг	СБД НЭ	НД ЭМТ	БХД ЭМТ	БНД ЭМТ	БНД ЭМТ	БНД ЭМТ	Энэүт-II
Хүндээвтэр	СХД НЭ	БГД ЭМТ Ачтан эмнэлэг	БЗД НЭ, ЦТЭ	СБД НЭ	СБД НЭ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	Энэүт-II
Хүнд	СХД НЭ	БГД ЭМТ Ачтан эмнэлэг	БЗД НЭ, ЦТЭ	СБД НЭ	СБД НЭ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	ХӨСҮТ	Энэүт-II
Маш хүнд	СХД НЭ, УГТЭ	Энэүт-II, БГД ЭМТ, УНТЭ ХӨСҮТ	БЗД НЭ, ЦТЭ	УНТЭ, ХӨСҮТ	СБД НЭ, УХТЭ	ХӨСҮТ	ЦТЭ	БНД ЭМТ, ХӨСҮТ	БНД ЭМТ, ХӨСҮТ	БНД ЭМТ, ХӨСҮТ	ХӨСҮТ
Гемодиализийн тусламж, Үйлчилгээ	Цэргийн төв эмнэлэг										Халдварт өвчин судлалын үндэсний төв
Хавдрын тусламж шаардлагайтай КОВИД-19 халдвартай иргэнд											Хавдар судлалын үндэсний төв
Эх барихын тусламж, үйлчилгээ шаардлагатай КОВИД-19 халдвартай иргэнд											Эх, хүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
Гэмтлийн тусламж, Үйлчилгээ шаардлагатай КОВИД-19 халдвартай иргэнд											Гэмтэл согог судлалын үндэсний төв
Сэтгэцийн тусламж, Үйлчилгээ шаардлагатай КОВИД-19 халдвартай иргэнд											Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
Арьсны тусламж, Үйлчилгээ шаардлагатай КОВИД-19 халдвартай иргэнд											Арьсны өвчин судлалын үндэсний төв
Яаралтай мэс заслын тусламж, Үйлчилгээ шаардлагатай иргэнд											Яаралтай мэс заслын тусламж, Үйлчилгээ шаардлагатай иргэнд төрөлжсөн мэргэшшийн чилгээний эмнэлгээс баг очиж мэс зааслын тусламж, Үйлчилгээ үзүүлнэ.
											Бусад төрөлжсан тусламж, Үйлчилгээ шаардлагатай иргэнд лавлагаа тусламж, Үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн мэргэшшийн эмнэлэгэ